



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
З.БОЛДБААТАР ТАНАА

2013.03.22 № 02/43 УАТ-САТ/2013/03/СТА-ТС

Зөрчил арилгуулах тухай

Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэр нь энхийг дэмжих үйл ажиллагаанд оролцсоны болон Монгол Улсын зэвсэгт хүчнээс ашиглуулж байгаа үндсэн болон туслах зэвсэглэл, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал хэрэгсэл, сургалт, бэлтгэлийн нөхөн төлбөр, зэвсэглэлээс хасагдаж акт тавигдсан зарим төрлийн техникийг худалдаж борлуулсны орлого зэргээс бүрддэг байна.

Олон улсын цэргийн ажиллагааны санхүүгийн үр дүнг орлого зарлагын зөрүүгээр тооцоход эдийн засгийн алдагдалтай байх төсөөлөл байгаа энэ үед улсын төсвийн хөрөнгө оруулалт болон төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх боломжтой асуудлуудыг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ гэдгээр сангийн хөрөнгөөс санхүүжүүлэх, зориулалтыг өөрчлөх, өр барагдуулах, сангийн эх үүсвэрийг хууль бусаар бүрдүүлэх болон нөөцийг хүндрүүлэх, энэ нь цаашид даамжрах хандлагатай байна. Үүнд:

-СЭЗСайдын/хуучин нэрээр/ 2004 оны 124 дүгээр тушаалын 2-т заасны дагуу Зэвсэгт хүчний "МИ-8" загварын нисдэг тэрэгний засварын ажлын зардалд зориулан тухайн онд БХЯ-нд олгосон 315,0 сая төгрөгийн зээлийн төлбөрийг Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронд 2004 онд байгуулсан "Монгол Улсад цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай" хэлэлцээрийн хүрээнд буцалтгүй тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээс суутган тооцож барагдуулахыг Төрийн сангийн газар/Ц.Даваасүрэн/-т даалгасан байхад төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа муугаас уг төлбөрийг 2011, 2012 онд Сангийн хөрөнгөөс төлж барагдуулсан,

-“Зэвсэгт хүчний АДХЦ-ийг хөгжүүлэх” дэд төслийн хүрээнд БХЯ, ОХУ-ын “ЛЭМЗ” үйлдвэрийн Монгол дахь төлөөлөгч “Эхэн трейд” ХХК-тай гэрээ байгуулж 2008 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,0 тэрбум төгрөгийн өртөгтэй П-18 загварын 2 нэгж РЛС-д “Лири-М” загвараар шинэчлэн сайжруулалт хийсэн бөгөөд дээрх төлбөрийн үлдэгдлийг Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Арбитрийн шийдвэрийн дагуу гэдгээр 2012 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 300.0 сая төгрөг, 12 дугаар сарын 26-ны өдөр 255.3 сая төгрөгийг тус тус Сангийн хөрөнгөөс төлж барагдуулсан,

-БХС-ын 2011 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 81 дүгээр тушаалаар бэлтгэл болон чөлөөнд гарсан генерал цолтнуудад эдлэн газрыг орон сууцны хамт олгож байх, холбогдох зардлыг Сангаас гаргахаар шийдвэрлэж нийт 324.1 сая төгрөг зарцуулсан,

-БХЯ-ны үүдний танхим, Зэвсэгт хүчний зарим анги салбаруудын урсгал болон их засвар, тохижилтод 1,294.0 сая төгрөг, тусламжаар ирүүлсэн техник тоног төхөөрөмж, тээврийн зардалд 715,5 сая төгрөг, Гадаад улсад суугаа батлан хамгаалахын атташегийн албанд шаардагдах тавилга хэрэгсэл, автомашины үнэд 63.4 сая төгрөгийг тус тус Сангийн хөрөнгөөс зарцуулсан,

-Энхийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор БХЯ-ны Барилга захиалагчийн албанаас 2,714.0 сая төгрөгийг татан төвлөрүүлэн зарцуулж оны эцэст буцаан төлсөн,


-Сангийн тайланд урьдчилж орсон орлогоор бүртгэгдсэн 2716,3 сая төгрөгийг хувь хүний хадгаламжийн дансанд байршуулж байгаад “Транс сэргэлт” ТӨААТҮГ-аас 2012 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр сангийн дансанд төвлөрүүлсэн бөгөөд уг хөрөнгийн эх үүсвэр болон зориулалт тодорхойгүй, өр авлагын тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь ЗГТСТХуулийн 32.1-д заасан “Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно”, Сангийн хөрөнгийг дараахь зориулалтаар ашиглана. 25/1/2.3.” Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг сэргээн сайжруулах, шинэчлэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх”, 25/1/2.4. “Энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдсон бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх”, 25/1/2.5. Энхийг дэмжих ажиллагаа, хүмүүнлэгийн сургалтыг Монгол Улсад зохион байгуулах”, 25.2.6-ийн “ батлан хамгаалах салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах” заалтуудтай зөрчилдөж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

Дээрх зөрчил дутагдлыг арилгаж хэрэгжилтийг 2013 оны 10 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Болдбаатар, СХОХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Батсүх нарт хариуцуулав.

Ахлах аудитор



Д.Ганбилэг